



СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



СҮХБААТАР АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ДЭРГЭДЭХ
СТАТИСТИКИЙН
ХЭЛТЭС

АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ 2022/05



sukhbaatar.nso.mn

www.nso.mn

www.1212.mn



Хэрэглэгч та Статистикийн
тоон мэдээллийн 1212.mn
аппликейшнаар авна уу.



Хэрэглэгч та өөрийн гар
утаснаас QR code уншуулагч
аппликейшни ашиглан тухай
сарын мэдээллийг авч үзэх.
/интернетэд холбогдсон байх/



СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

СҮХБААТАР АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

5 сар
2022

Баруун-Урт сум



ГАРЧИГ

Ерөнхий тэмдэглэл	3
Аргачлалын тайлбар	4-5
Товч танилцуулга	6-12
Үндсэн үзүүлэлтүүд	13
I. Нийгмийн үзүүлэлт	
I.2 Хөдөлмөр	14-16
I.3 Нийгмийн халамж	17
I.4 Эрүүл мэнд	18-19
I.5 Гэмт хэрэг	20-21
II. Эдийн засгийн үзүүлэлт	
II.1 Мөнгө, банк	22
II.2 Төрийн санхүү	22-24
II.3 Үнэ	25-26
II.4 Хөдөө аж ахуй	27-30
II.5 Аж үйлдвэр	31-33



Ерөнхий тэмдэглэл

I. Товчилсон үгийн тайлал:

Сумдын нэр:

АС Асгат	ТШ Түвшинширээ
БД Баяндэлгэр	ТЦ Түмэнцогт
ДА Дарьганга	УБ Уулбаян
МХ Мөнххаан	ХА Халзан
НА Наран	ЭЦ Эрдэнэцагаан
ОН Онгон	БУ Баруун-Урт
СҮ Сүхбаатар	

Төл гэсэн нь төлөвлөгөө, Гүйц гэсэн нь гүйцэтгэл юм.

II. Саруудыг ром тоогоор тэмдэглэв. (I, II, III, IV, V, VI, VII ...г.м)

Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдэх дүнг харуулахдаа I-IV, I-XI зэргээр илэрхийлэв.

III. Дараах тэмдэглэлийг ашиглав:

... Мэдээлэл байхгүй	х Бүтцийн өөрчлөлт
0.0 Маш бага тоо	+, - Зөрүү
- Гүйцэтгэл байхгүй	* Дахин

┌ "Үүнээс" гэдгийг харуулах бөгөөд зарим тохиолдолд тухайн үзүүлэлтийн бүрэлдэхүүн хэсгүүдийн нийлбэр нэгдсэн дүнтэй тэнцэхгүй байж болно.

IV. 22-21 нь 2021 оны үзүүлэлт тухайн оны үзүүлэлтээс өсч, буурсан абсолют өөрчлөлт.

V. Орон дэвшүүлэхээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас их, бага зэрэг зөрүүтэй байж болно.



АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР

- **Хөдөлмөр:** Бүртгэлтэй ажилгүй иргэдэд Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхтэй хайж байгаа Хөдөлмөрийн хэлтэст бүртгүүлсэн хүмүүс орсон болно.
- **Эрүүл мэнд, Гэмт хэрэг:** Уг салбарын мэдээнүүдийг холбогдох газар, хэлтсүүд нь нэгтгэн гаргаж ирүүлдэг.
 - **1 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг** 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.
 - **1-5 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг** 1-5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.
- **Эрүүгийн хуульд** эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан, нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхгүйг гэмт хэрэг гэнэ. Гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, оногдуулж болох ялын хүнд, хөнгөнийг харгалзан гэмт хэргийг хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд гэж ангилна.

Эрүүгийн хууль шинэчлэгдсэнтэй холбогдон гэмт хэргийн нэр төрөл урьдынхаас нилээд өөрчлөгдсөн.

 - Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэгт бусдыг амиа хорлоход хүргэх, иргэдийн эрх чөлөө, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг болон хүнийг санаатай алах, болгоомжгүйгээс алах хэргийг нэгтгэн оруулсан.
 - Хүүхэд гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэгт хүчингийн хэргийг оруулсан.
 - Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгт бусдын эд хөрөнгийг хулгайлах, бусдын эд хөрөнгийг булаах, бусдын эд хөрөнгийг дээрэмдэх, бусдыг эд хөрөнгийг залилан мэхэлж авах, бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх гэмт хэргийг хамруулсан.
 - Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгт танхайн гэмт хэргийг оруулсан.
 - 18 ба түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэргийн тоог гаргахдаа нийт бүртгэгдсэн гэмт хэргийн тоог оны эхний 18 ба түүнээс дээш насны хүн амд харьцуулан тооцно.



- **Хэрэглээний үнийн индекс / ХҮИ / гэдэг нь** хэрэглэгчдийн худалдаж авсан бараа үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.
 - Үндэсний статистикийн хороо нь хэрэглээний үнийн улсын индексийг Улаанбаатар хотын ХҮИ-ээр тооцож байсан аргачлалаа шинэчилж, 2008 оны 1 дүгээр сараас олон улсын нийтлэг арга зүйн дагуу хэрэглээний үнийн улсын индексийг аймаг, нийслэлийн өрхийн 2010 оны хэрэглээний зардлаар жигнэсэн дундаж үзүүлэлтээр тооцох аргачлалд шилжсэн.
- **Мөнгө, банк:** Монгол банк арилжааны банкнуудаас мэдээг авч нэгтгэн, банкнуудын үндсэн материалын хамт ирүүлдэг.
- **Төрийн санхүү:** Төсвийн орлого, зарлагын мэдээг Олон Улсын Валютын Сангийн стандарт ангиллаар 1995 оны 10-р сараас эхлэн жил бүр гаргаж байна. Аймгийн төсвийн орлого нь аймаг, сумын төсвийн орлогоос бүрдэнэ. Аймгийн нэгдсэн төсөв нь татварын болон татварын бус орлого, улсаас авах санхүүгийн дэмжлэг, тусгай зориулалтын шилжүүлгийн орлого, орон нутгийн сангийн орлогын шилжүүлэг зэргээс бүрдэнэ. Төсвийн мэдээг Санхүү төрийн сангийн хэлтэс үндсэн нэгжүүдээс авч нэгтгэн ирүүлдэг.
- Аймгийн төсвийн мэдээг Санхүү, төрийн сангийн хэлтэс үндсэн нэгжүүдээс авч нэгтгэн ирүүлдэг.
- **Хөдөө аж ахуй:** Газар тариалангийн эцсийн мэдээг багийн Засаг дарга нар өрхөөс цуглуулах ба аж ахуй нэгж байгууллагууд сумын тамгын газарт салбар хариуцсан ажилтанд өгч нэгтгэн ирүүлдэг.
- **Аж үйлдвэр:** Аж ахуйн нэгжүүдийг эдийн засгийн үйл ажиллагаагаар ангилахдаа Нэгдсэн үндэсний байгууллагын эдийн засгийн үйл ажиллагааны Олон улсын стандарт ангиллыг мөрдөж байна. Үндсэн нэгжүүд мэдээг ирүүлдэг.

Нийт бүтээгдэхүүний өсөлтийг тооцохдоо: гол нэр төрлийн бүтээгдэхүүнийг 2010 оны зэрэгцүүлэх үнээр үнэлж тодорхойлсон болно.


Борлуулсан бүтээгдэхүүн нь аж ахуйн нэгж, байгууллагын тайлангийн хугацаанд оны үнээр үнэлж, худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

Гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл нь тухайн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн биет хэмжээг харуулна.

**Сүхбаатар аймгийн нийгэм, эдийн засгийн байдал****I. Нийгмийн үзүүлэлт****I.1 Өрх, Хүн ам**

Эрүүл мэндийн газрын мэдээллээр эхний 5 сард 410 хүүхэд шинээр мэндэлж 135 хүн нас баржээ. Хүн амын цэвэр өсөлт 275 болж урьд оны мөн үеэс 178 (39.3%)-аар буурчээ. 1000 хүнд ногдох төрөлт 6.4, нас баралт 2.1 пункттэй байна.


Зураг.I.1 Төрсөн хүүхэд, нас барсан хүний тоо

**I.2 Хөдөлмөр**

Хөдөлмөр, халамж үйлчилгээний газарт бүртгүүлсэн ажил хайгч иргэдийн тоо 2022 оны 5 дугаар сарын эцэст 640 болсны 232 (36.3%) нь эмэгтэйчүүд байна. Эдгээр бүртгэлтэй ажил хайгчдын 495 нь ажилгүй иргэд байгаа нь өмнөх оны мөн үеэс 91 (22.5%) хүнээр өссөн байна.

Эхний 5 сарын байдлаар хөдөлмөр халамж үйлчилгээний газарт 832 ажилгүй иргэн шинээр бүртгүүлсний 85 (10.2%) иргэн ажилд зуучлагдан оржээ.

Зураг.I.2. Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад шинээр бүртгүүлсэн болон ажилд зуучлагдан орсон иргэд






Ажилгүй иргэдийн 405 (81.8%) нь 15-44 насны залуучууд эзэлж байна.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 1 (0.2%) нь магистр, доктор, 90 (18.2%) нь бакалавр, 14 (2.8%) нь тусгай дунд, 28 (5.7%) нь мэргэжлийн анхан шатны боловсролтой, 279 (56.4%) нь бүрэн дунд, 62 (12.5%) нь суурь, 18 (3.6%) нь бага боловсролтой, 3 (0.6%) боловсролгүй хүмүүс байна.

Зураг.1.3. Бүртгэлтэй ажилгүй иргэд, боловсролын түвшингээр



Эхний 5 сарын байдлаар 125 шинэ ажлын байр бий болсон нь, өмнөх оны мөн үеэс 7 (5.9%) -оор өссөн байна.



1.3 Нийгмийн даатгал, халамж:

Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын мэдээллээр 05 дугаар сард 24.1 мянган иргэнд 4.9 тэрбум төгрөгийн хөнгөлөлт, тусламж, дэмжлэгийг олгосон байна. Үүнийг төрлөөр нь авч үзвэл: Улсын төсвөөс нийгмийн халамжийн тэтгэврийг 1.3 мянган иргэнд 1.8 тэрбум төгрөг, нийгмийн халамжийн тэтгэмжийг 2.1 мянган иргэнд 0.8 тэрбум төгрөг, бусад хөнгөлөлт, тусламж, дэмжлэгт 20.8 мянган иргэнд 2.2 тэрбум төгрөгийг, эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмжийг 4.6 мянган иргэнд 0.9 тэрбум төгрөгийг тус тус олгожээ.



1.4 Эрүүл мэнд


Аймгийн хэмжээнд эхний 5 сарын байдлаар 106.0 мянган хүнд үзлэг хийсэн ба урьдчилан сэргийлэх үзлэгт 21.2 мянган хүн хамрагдаж, 6.8 мянган хүн эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн байна. Урьдчилан сэргийлэх үзлэгт 21.1 мянган хүн хамрагдсан нь урьд оны мөн үеэс 7.2 (25.4%) мянган хүнээр буурсан.

Түргэн тусламжийн дуудлага 7.4 мянган удаа гарсны 1.4 (18.4%) мянга нь алсын дуудлага байгаа нь урьд оны мөн үеэс 0.1 (6.7%) мянган удаагийн дуудлагаар буурсан байна.

Аймгийн хэмжээнд амаржсан эх 411, амьд төрсөн хүүхдийн тоо 410 болж, урьд оны мөн үеэс амаржсан эхийн тоо 169 (29.1%), хүүхдийн тоо 175 (29.9%)-аар тус тус буурсан байна.



Зураг.1.4. Амаржсан эх, амьд төрсөн хүүхдийн тоо



5 сарын байдлаар 3.5 мянган халдварт өвчний тохиолдол бүртгэгдэж өмнөх оны мөн үеэс 3.1 (8.1 дахин) мянган тохиолдлоор өсөхөд коронавирус /ковид-19/ халдвар 3.1 мянгаар нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.



1.5 Гэмт хэрэг


Аймгийн хэмжээнд 2022 оны эхний 5 сард 274 гэмт хэрэг бүртгэгдэж, өмнөх оноос 116 (57.7%)-аар өсчээ.

Бүртгэгдсэн гэмт хэргийн улмаас 8 хүн нас барж, 59 хүн гэмтэж бэртсэн бөгөөд аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд 982.4 сая төгрөгийн хохирол учирсны 40.3 хувийг нөхөн төлүүлсэн байна.

Гэмт хэрэгт 217 хүн холбогдон сэжиглэгдсэний 56 (25.8%) хүн нь согтуугаар хэрэг үйлджээ.

Нийт 177 хүн эрүүлжигдсэн нь өмнөх оны мөн үеэс 1 (0.6%) хүнээр өссөн байна. Нийт эрүүлжигдсэн хүмүүсээс 70 хүн баривчлагдаж захиргааны арга хэмжээ авахуулсан байна.

Зураг.1.5. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо





II. Эдийн засгийн үзүүлэлт




II.1 Мөнгө, банк:

Монгол банкны мэдээллээр ХААН, Төрийн, Хас, Голомт банкнуудаас аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдэл 192.8 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 50.4 (35.4%) тэрбум төгрөгөөр өсчээ.

Банкнуудад хадгалуулсан иргэдийн төгрөгийн хадгаламжийн хэмжээ 141.2 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 9.2 (6.1%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

Чанаргүй хугацаа хэтэрсэн зээл 5 дугаар сарын эцэст 1.5 тэрбум болж, нийт зээлийн өрийн үлдэгдлийн 0.8 хувийг эзэлж байна.

Зураг.II.1. Зээлийн өрийн үлдэгдэл, хадгаламжийн үлдэгдэл, тэрбум.төг




II.2 Төрийн санхүү:

Аймгийн төсвийн нийт орлого 2022 оны 5 дугаар сарын байдлаар 27.6 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 2.4 (8.0%) тэрбум төгрөгөөр, төсвийн зарлага санхүүжилт 24.9 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 4.4 (15.0%) тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна.

Аймгийн нийт төсвийн 18.7 хувийг орон нутгийн төсвийн орлого, 12.6 хувийг Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг, 6.8 хувийг аймгаас авсан санхүүгийн дэмжлэг, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг 16.3 хувийг, 43.4 хувийг урьд оны үлдэгдэл, 2.2 хувийг төсөвт байгууллагын өөрийн орлого тус тус эзэлж байна.



Зураг.II.2. Төсвийн орлого, зарлага, тэрбум.төг




II.3 Хэрэглээний үнийн индекс

Хэрэглээний үнийн индекс гэдэг нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмждэг үзүүлэлт юм.

Хэрэглээний үнийн индекс 2022 оны 05 дугаар сард өмнөх сараас 1.1 хувь, өмнөх оны мөн үеэс 15.5, жилийн эцсээс 6.4 хувиар тус тус өссөн.

Зураг.II.3 Хэрэглээний үнийн индекс (өмнөх оны 12 сар=100)



Ерөнхий индекс жилийн эцсээс 6.4 хувиар өсөхөд хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлгийн үнэ 11.2 хувь, согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодисын бүлгийн үнэ 0.4 хувь, хувцас бөс барааны бүлгийн үнэ 1.9 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш 3.6 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн үнэ 9.1 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ 9.0 хувь, тээврийн бүлгийн үнэ 5.1 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээний бүлгийн үнэ 1.5 хувь, боловсролын үйлчилгээний бүлгийн үнэ 2.1



хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлгийн үнэ 2.7 хувь, бусад бараа, үйлчилгээ 10.0 хувиар тус тус өссөн нь нөлөөлжээ.

Хүснэгт. II.3. Хэрэглээний үнийн үнийн индекс, бүлгээр

Бараа үйлчилгээний бүлэг	$\frac{2022.IV}{2021.V}$	$\frac{2022.V}{2021.XII}$	$\frac{2022.V}{2022.IV}$
Ерөнхий индекс	155.5	106.4	101.1
Хүнсний бараа, согтууруулах бус ундаа	117.2	111.2	101.5
Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис	103.9	100.4	100.3
Хувцас, бөс бараа, гутал	112.9	101.9	100.9
Орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш	113.9	103.6	101.1
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	122.1	109.1	102.8
Эм тариа, эмнэлэгийн үйлчилгээ	119.0	109.0	101.8
Тээвэр	122.4	105.1	100.0
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	100.0	100.0	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээ	103.3	101.5	100.9
Боловсролын үйлчилгээ	103.5	102.1	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	110.4	102.7	104.2
Бусад бараа, үйлчилгээ	114.3	110.0	100.8



II.4 Хөдөө аж ахуй

Мал төллөлт төл бойжилт. Оны эхний төллөх насны хээлтэгч малын 1524.8 (81.5%) мянган хээлтэгч мал төллөсөн байна. Таван төрлөөр нь авч үзвэл: эм хонь 84.5 хувь нь, эм ямаа 82.3 хувь нь, үнээ 67.9 хувь нь ингэ 38.1 хувь нь, гүү 66.2 хувь нь тус тус төллөжээ.

Гарсан төлийн 1515.9 (99.2%) мянган төл бойжиж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 171.9 (12.8%) мянган толгойгоор өссөн байна.


5 дугаар сарын байдлаар төл бойжилтыг төрлөөр нь авч үзвэл: хурга 99.4 хувь, ишиг 98.8 хувь, унага 99.5 хувь, тугал 99.4 хувь, ботго 99.2 хувь байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 0.1-0.7 пунктээр тус тус өссөн байна.

Малын онд оролт: Том малын зүй хорогдол 2022 оны 5 дугаар сард 10098 толгой болж өмнөх оны мөн үеэс 27.2 мянган толгой буюу 72.9 хувь буурсан байна. Том малын хорогдлыг төрлөөр нь авч үзвэл: тэмээ 21 толгой, адуу 1187 толгой, үхэр 1160 толгой, хонь 3727 толгой, ямаа 4003 толгой байна. Нийт хорогдлын 36.9 хувийг хонь, 39.6 хувийг ямаа эзэлж байна.

Аймгийн хэмжээнд 2022 оны 5 дугаар сард 119 толгой мал өвчнөөр хорогдож нийт хорогдлын 1.2 хувийг эзэлж байна.



Зураг-II.4. Том малын зүй бус хорогдол



II.5 Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2010 оны зэрэгцүүлэх үнээр 20.8 тэрбум төгрөг болж өмнөх оноос 0.6 (3.0%) тэрбум төгрөгөөр өсчээ. Ангиллаар нь өмнөх онтой харьцуулан авч үзвэл: уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарынх 1.1 (6.5%) тэрбум төгрөг, цахилгаан дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамжийн салбарынх 0.2 (9.7%) тэрбум төгрөгөөр тус тус өсч, боловсруулах аж үйлдвэрийнх 0.7 (44.9%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

Оны үнээр 105.5 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь өмнөх оны мөн үеэс 3.2 (2.9%) тэрбум төгрөгөөр доогуур гүйцэтгэлтэй байна.

Гол нэр төрлийн бүтээгдэхүүнээс цайрын баяжмал, хайлуур жонш, дулаан, түгээсэн цэвэр ус, цахилгаан, бууз, банш, бялуу, нарийн боов, талх, хэрчсэн гурил, хийжүүлсэн цэвэр ус, борц, монгол дээл, тэрлэг болон бусад монгол хувцас, гэрийн бүрээс туурга бусад хэрэгсэл, оёмол болоо нэхмэл бүтээгдэхүүн зэрэг нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт өмнөх оны мөн үеэс өссөн байна.

СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА

Т.ЭРДЭНЭБАТ



ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн эцсийн байдлаар

	Хэмжих нэгж	2020	2021	2022	Зөрүү	$\frac{2022}{2021}$ %
Нийгмийн статистикийн үзүүлэлтүүд						
Төрсөн хүүхэд	хүн	534	585	410	- 175	70.1
Нялхасын эндэгдэл	хүн	6	1	5	4	500.0
Бүртгэлтэй ажилгүй иргэд	хүн	467	404	495	91	122.5
Халдварт өвчнөөр өвчлөгчид	хүн	216	435	3 517	3 082	808.5
Бүртгэгдсэн гэмт хэрэг	тоо	236	158	274	116	173.4
Хэрэгт холбогсод	хүн	134	100	217	117	217.0
Макро эдийн засгийн статистикийн үзүүлэлт						
Хэрэглээний үнийн индексийн өөрчлөлт, оны эцэстэй харьцуулснаар, хувиар	хувь	104.2	103.9	106.4	2.5	-
Иргэдийн хадгаламж	сая.төг	95 187.6	150 414.8	141 236.5	-9 178.3	93.9
Зээлийн өрийн үлдэгдэл	сая.төг	131 735.4	142 371.8	192 782.9	50 411.1	135.4
Орон нутгийн төсвийн орлого	сая.төг	29 895.7	30 007.7	27 599.6	-2 408.1	92.0
Орон нутгийн төсвийн зарлага	сая.төг	28 249.0	29 247.0	24 867.2	-4 379.8	85.0
Төллөсөн хээлтэгч	тол	1 348 158	1 352 931	1 524 772	171 841	112.7
- Ингэ	тол	1 143	902	1 161	259	128.7
- Гүү	тол	58 461	61 556	77 470	15 914	125.9
- Үнээ	тол	61 584	65 502	82 249	16 747	125.6
- Эм хонь	тол	762 936	764 207	865 267	101 060	113.2
- Эм ямаа	тол	464 034	460 764	625	- 460 139	0.1
Бойжуулсан төл	тол	1 334 931	1 344 090	1 515 943	171 853	112.8
- Ботго	тол	1 136	888	1 152	264	129.7
- Унага	тол	57 783	61 027	77 055	16 028	126.3
- Тугал	тол	60 986	64 984	81 793	16 809	125.9
- Хурга	тол	756 444	760 756	861 572	100 816	113.3
- Ишиг	тол	458 582	456 435	494 371	37 936	108.3
Том малын зүй бусын хорогдол	тол	31 528	37 258	10 098	- 27 160	27.1
- Тэмээ	тол	16	23	21	- 2	91.3
- Адуу	тол	1 166	1 448	1 187	- 261	82.0
- Үхэр	тол	2 331	3 520	1 160	- 2 360	33.0
- Хонь	тол	15 823	15 214	3 727	- 11 487	24.5
- Ямаа	тол	12 192	17 053	4 003	- 13 050	23.5
Үүнээс: Өвчнөөр хорогдсон мал	тол	136	5	119	114	23.8*
- Тэмээ	тол	-	-	-	-	-
- Адуу	тол	1	-	-	-	-
- Үхэр	тол	10	5	21	16	4.2*
- Хонь	тол	60	-	45	-	-
- Ямаа	тол	65	-	53	-	-
Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн	сая.төг	17 532.9	20 235.9	20 844.3	608.4	103.0
Борлуулсан бүтээгдэхүүн	сая.төг	64 487.1	108 706.0	105 526.0	-3 180.0	97.1

**I.2 ХӨДӨЛМӨР****I.2.1 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, сумаар**

Сум	2020		2021		2022	$\frac{2022.V}{2021.V} \%$
	V	XII	V	XII	V	
Асгат	2	10	3	8	9	3.0*
Баяндэлгэр	29	9	21	51	8	38.1
Дарьганга	42	35	32	34	34	106.3
Мөнххаан	25	7	1	38	6	6.0*
Наран	27	28	12	6	5	41.7
Онгон	28	11	12	37	2	16.7
Сүхбаатар	58	55	41	48	18	43.9
Түвшинширээ	18	57	44	83	72	163.6
Түмэнцогт	35	20	16	30	6	37.5
Уулбаян	72	32	44	10	9	20.5
Халзан	2	4	4	15	-	-
Эрдэнэцагаан	32	50	45	32	55	122.2
Баруун-Урт	97	144	129	171	271	210.1
Дүн	467	462	404	563	495	122.5

I.2.2 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, сумаар, боловсрол, насны бүлгээр

Сум	Бүгд	эмэгтэй	Боловсролын түвшингээр								Насны бүлгээр					
			Магистр, доктор	Дээд боловсролтой	Тусгай дунд боловсролтой	Мэргэжлийн анхан шатны	Бүрэн дунд боловсролтой	Суурь	Бага	Боловсролгүй	15-24	25-34	35-44	45-54	55-59	60+
Асгат	9	2	-	1	-	2	4	2	-	-	2	4	1	2	-	-
Баяндэлгэр	8	2	-	2	-	1	5	-	-	-	3	2	2	1	-	-
Дарьганга	34	18	-	5	-	6	16	7	-	-	9	11	6	7	1	-
Мөнххаан	6	3	-	2	-	-	3	-	1	-	2	-	3	1	-	-
Наран	5	4	-	1	1	-	1	2	-	-	1	-	4	-	-	-
Онгон	2	2	-	1	-	-	1	-	-	-	1	1	-	-	-	-
Сүхбаатар	18	8	-	2	1	-	13	1	1	-	4	11	1	2	-	-
Түвшинширээ	72	37	-	14	5	5	24	19	5	-	13	25	18	13	2	1
Түмэнцогт	6	1	-	4	-	-	1	-	-	1	-	5	-	1	-	-
Уулбаян	9	5	-	4	-	2	2	-	1	-	2	6	-	-	-	1
Халзан	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Эрдэнэцагаан	55	18	-	2	-	-	49	2	1	1	11	16	20	8	-	-
Баруун-Урт	271	74	1	52	7	12	160	29	9	1	38	93	90	45	5	-
Дүн	495	174	1	90	14	28	279	62	18	3	86	174	145	80	8	2



I.2.3 ШИНЭЭР БҮРТГҮҮЛСЭН АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, сумаар

Сум	2020		2021		2022	$\frac{2022.V}{2021.V} \%$
	I-V	I-XII	I-V	I-XII	I-V	
Асгат	10	30	17	95	23	135.3
Баяндэлгэр	88	156	26	193	11	42.3
Дарьганга	28	55	69	177	77	111.6
Мөнххаан	60	184	12	96	13	108.3
Наран	48	118	36	98	34	94.4
Онгон	24	122	36	141	6	16.7
Сүхбаатар	28	157	23	122	34	147.8
Түвшинширээ	39	228	66	258	109	165.2
Түмэнцогт	43	137	43	125	25	58.1
Уулбаян	102	158	46	124	15	32.6
Халзан	32	41	10	39	6	60.0
Эрдэнэцагаан	38	110	38	103	62	163.2
Баруун-Урт	220	783	356	1 018	417	117.1
Дүн	760	2 279	778	2 589	832	106.9

SS

I.2.4 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДЭЭС АЖИЛД ОРСОН ХҮНИЙ ТОО, сумаар

Сум	2020		2021		2022	$\frac{2022.V}{2021.V} \%$
	I-V	I-XII	I-V	I-XII	I-V	
Асгат	4	9	5	52	10	200.0
Баяндэлгэр	38	65	1	35	1	100.0
Дарьганга	16	37	-	30	7	-
Мөнххаан	13	51	3	29	1	33.3
Наран	38	79	16	52	17	106.3
Онгон	-	43	7	49	-	-
Сүхбаатар	12	110	10	21	-	-
Түвшинширээ	13	69	11	81	9	81.8
Түмэнцогт	2	33	11	43	2	18.2
Уулбаян	47	52	-	37	2	-
Халзан	17	17	2	10	4	200.0
Эрдэнэцагаан	1	9	1	7	2	200.0
Баруун-Урт	29	272	46	161	29	63.0
Дүн	230	846	113	607	85	75.2

Ы



I.2.5 ШИНЭ АЖЛЫН БАЙРАНД АЖИЛЛАЖ БАЙГАА ХҮНИЙ ТОО, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар

Сум	Шинэ ажлын байранд орсон хүний тоо				Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар									
					Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт,ан агнуур	Уул уурхай, олборлолт	Боловсруулах аж үйлдвэр	Усан хангамж, бохир ус, хог хаягдлын менежмент	Бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээ	Байр орон сууц болон хоол хүнсэр үйлчлэх үйл ажиллагаа	Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	
	2021.I-V	2022.I-V												
		Бүгд	Үүнээс											
Байн-гын	Түр		Улирал											
Асгат	-	7	-	7	-	2	-	-	-	5	-	-	-	-
Баяндэлгэр	20	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Дарьганга	9	1	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Мөнххаан	11	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Наран	8	5	5	-	-	-	-	-	1	1	-	-	4	-
Онгон	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Сүхбаатар	11	15	1	14	-	7	-	1	-	-	1	5	-	1
Түвшинширээ	-	1	1	-	-	-	-	-	-	1	-	-	-	-
Түмэнцогт	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Уулбаян	33	7	7	-	-	1	3	-	-	-	-	-	3	-
Халзан	15	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Эрдэнэцагаан	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Баруун-Урт	11	89	89	-	-	-	89	-	-	-	-	-	-	-
Дүн	118	125	104	21	-	10	92	1	1	7	1	5	7	1



I.3.3 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ, сая.төг

Үзүүлэлт		2021.V		2022.V	
		Хүн тоо	сая.төг	Хүн тоо	сая.төг
Улсын төсөвөөс	1 Халамжийн тэтгэвэр	1 256	1 804.2	1 313	1 815.5
	2 Халамжийн тэтгэмж	1 993	797	2 084	841.1
	1. Асаргааны тэтгэмж	1 079	463	1 078	465
	байнгын асаргаа шаардлагатай				
	Ахмад настныг асарч байгаа иргэд олгох тэтгэмж	610	240.0	608	232.6
	Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч байгаа иргэд олгох тэтгэмж	217	83.6	200	79.6
	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асарч байгаа иргэд олгох тэтгэмж	214	123.7	226	133.1
	Бүтэн өнчин хүүхдийг үрчлэн авсан болон асран хамгаалж харгалзан дэмжиж байгаа иргэнд олгох тэтгэмж	15	6.0	18	8.0
	Гэр бүлийн тухай хуульд заасны дагуу хүүхдийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэнд олгох тэтгэмж	7	3.8	5	3.7
	Хүүхэд, төрөл садангүй ганц бие ахмад настан болон ХБ иргэнийг гэр бүлдээ авч асран хамгаалах	16	5.9	21	8.0
	3 Хүнс тэжээлийн хөтөлбөрийн зардал	5 739	342.9	3 090	144.3
	4 Ахмад настны нийгмийн хамгаалалын тухай хуулийн дагуу олгогдож байгаа хөнгөлөлт тусламж	4 291	71.8	4 569	141.9
	5 Алдар цолтой ахмадуудад олгосон хөнгөлөлт тусламж	-	-	2	0.3
	6 ХБ-тэй иргэнд олгогдож буй хөнгөлөлт, тусламж	297	42.4	285	44.7
	7 Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж	4 061	965.3	4 600	919.9
	0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмж	3 289	785.2	3 711	814.1
	Жирэмсэн эхийн тэтгэмж	632	112.6	883	93.8
	Ихэр хүүхдийн тэтгэмж	8	16.0	6	12.0
	3 ба түүнээс дээш тооны хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэст жилд 1 удаа	132	51.5	0	0
Халамжийн сангаас	8 Насны хишиг	2 682	216.7	2 836	223.8
	9 Алдар эхийн одонтой эхчүүдэд олгосон тусламж	5 236	698.7	5 347	704.5
	1 Амжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмж	914	334.2	1 006	376.1
	Байнгын асаргаа шаардлагатай 16 ба түүнээс дээш насны иргэн	706	47.5	759	45.3
	16 хүртэлх насны байнгын асаргаа шаардлагатай хүүхдэд олгох мөнгөн тэтгэмж	208	286.7	233	314.0
	18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэн	-	-	6	7.2
	удаа олгох тэтгэмж	-	-	5	6
	Хорих ангиас суллагдсан өөрийн орон гэргүй иргэн	-	-	3	3.6
	2 Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ	1	1.4	50	30.5
	ДҮН	26 469	5 273.4	24 176	4 866.5

**I.4 ЭРҮҮЛ МЭНД****I.4.1 ЭРҮҮЛ МЭНД**

	Хэмжих нэгж	2021.I-V	2022.I-V	Өсөлт	
				тоо	%
1. Нийт үзлэг	мян.хүн	89.2	105.9	16.7	118.7
2. Ор хоног	мян.хүн	35.4	55.2	19.8	155.9
3. Урьдчилан сэргийлэх үзлэг	мян.хүн	28.3	21.1	-7.2	74.6
4. Эмчлүүлсэн хүний тоо	мян.хүн	4.4	6.8	2.4	154.5
5. Түргэн тусламжийн дуудлага	мян.хүн	6.4	7.4	1	115.6
Үүнээс: алсын дуудлага	мян.хүн	1.5	1.4	-0.1	93.3
6. Осол гэмтлийн дуудлага	хүн	118	122	4	103.4
Нийт нас баралт	хүн	132	135	3	102.3
8. Амаржсан эх	хүн	580	411	-169	70.9
Үүнээс: амьд төрсөн хүүхэд	хүн	585	410	-175	70.1
9. 1 хүртэл насандаа эндсэн хүүхэд	хүн	1	5	4	5.0*
10. 1-5 хүртэлх насны эндсэн хүүхэд	хүн	1	4	3	4.0*

I.4.2 ТӨРӨЛТ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, сумаар

Сум	Амаржсан эх	Амьд төрсөн хүүхэд	1 хүртэл насандаа эндсэн хүүхэд	1-5 хүртэл насны эндсэн хүүхэд
Асгат	-	-	1	-
Баяндэлгэр	3	3	1	-
Дарьганга	-	-	1	1
Мөнххаан	-	-	-	-
Наран	-	-	-	-
Онгон	5	5	-	1
Сүхбаатар	2	2	-	-
Түвшинширээ	1	1	-	-
Түмэнцогт	2	2	-	-
Уулбаян	-	-	-	-
Халзан	-	-	1	-
Эрдэнэцагаан	12	12	-	-
Баруун-Урт	386	385	1	2
Дүн	411	410	5	4



I.4.3 ХАЛДВАРТ ӨВЧНИЙ ГАРАЛТ

Халдварт өвчин	Хэмжих нэгж	2021.I-V	2022.I-V	Өсөлт	
				тоо	хувь
Вируст гепатит	хүн	3	2	-1	66.7
Гар хөл амны өвчин	хүн	19	1	-18	5.3
Бруцеллёз	хүн	-	1	1	-
Цусан суулга	хүн	12	2	-10	16.7
Салхинцэцэг	хүн	3	5	2	166.7
Сүрьеэ	хүн	26	32	6	123.1
Тэмбүү	хүн	31	15	-16	48.4
Трихоминиаз	хүн	36	36	0	100.0
Заг	хүн	31	21	-10	67.7
Ковид-19	хүн	274	3 402	3 128	12.4*
Бүгд	хүн	435	3 517	3 082	8.0*

I.4.4 ХАЛДВАРТ ӨВЧНӨӨР ӨВЧЛӨГЧДИЙН ТОО, сумаар

Сум	Халдвар өвчнөөр өвчлөгчид бүгд			Вируст гепатит	Гар хөл амны өвчин	Цусан суулга	Салхинцэцэг	Сүрьеэ	Тэмбүү	Заг	Трихоминиаз	Бруцеллёз	Ковид-19
	2021.I-V	2022.I-V	1000 хүн тутамд										
Асгат	10	139	70.0	1	-	-	-	2	1	-	-	-	135
Баяндэлгэр	10	347	67.8	-	-	-	-	4	-	1	1	1	340
Дарьганга	2	69	21.6	-	-	-	-	-	-	-	4	-	65
Мөнххаан	101	145	28.9	-	-	-	-	-	1	-	1	-	143
Наран	3	26	15.5	-	-	-	1	-	-	1	-	-	24
Онгон	98	163	42.5	-	-	-	-	3	-	-	-	-	160
Сүхбаатар	53	100	27.8	-	-	-	-	3	2	4	3	-	88
Түвшинширээ	6	41	11.9	-	-	-	-	-	-	-	-	-	41
Түмэнцогт	6	45	17.6	-	-	-	-	2	-	-	-	-	43
Уулбаян	11	89	30.4	-	-	-	-	-	-	-	-	-	89
Халзан	5	139	76.6	-	-	-	1	-	1	-	-	-	137
Эрдэнэцагаан	8	84	12.1	-	-	-	-	3	-	1	4	-	76
Баруун-Урт	122	2 130	92.2	1	1	2	3	15	10	14	23	-	2 061
Дүн	435	3 517	514.9	2	1	2	5	32	15	21	36	1	3 402

**I.5 ГЭМТ ХЭРЭГ****I.5.1 БҮРТГЭГДСЭН ХЭРГИЙН ТОО, төрлөөр**

Хэргийн төрөл	2020.I-V	2021.I-V	2022.I-V
Бүртгэгдсэн хэрэг-бүгд	197	158	274
Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	3	2	5
Хүний эрүүл мэнд халдашгүй байдлын гэмт хэрэг	47	56	48
Хүний бэлгийн эрх чөлөө халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	6	4	11
Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	118	74	179
Бусдын эд хөрөнгийг хулгайлах	99	50	98
Үүнээс: Хувийн өмчийг хулгайлах	46	19	43
Малын хулгай	51	29	55
Олон нийтийн аюулгүй байдлын ашиг сонирхолын эсрэг гэмт хэрэг	-	7	-
Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	7	1	16
Бусад гэмт хэрэг	16	21	16
Гэмт хэргийн улмаас учирсан хохирол			
Гэмтэж осолдсон хүн	48	56	59
Нас барсан хүн	8	3	8
Нийт хохирол /сая төгрөг/	1 141.0	288.5	982.4
Нөхөн төлүүлсэн хохирол /хувь/	10.9	30.3	40.3

I.5.2. БҮРТГЭГДСЭН ХЭРГИЙН ТОО, сумаар

Сум	2020.I-V	2021.I-V	2022.I-V
Асгат	1	5	12
Баяндэлгэр	17	4	2
Дарьганга	9	11	7
Мөнххаан	19	17	25
Наран	5	4	13
Онгон	3	2	9
Сүхбаатар	31	13	36
Түвшинширээ	7	4	11
Түмэнцогт	5	7	19
Уулбаян	13	6	13
Халзан	15	1	7
Эрдэнэцагаан	24	15	23
Баруун-Урт	48	69	97
Дүн	197	158	274



I.5.3. СЭЖИГТЭН, ЯЛЛАГДАГЧИЙН ТОО

Сэжигтэн, яллагдагчийн тоо	2020.I-V	2021.I-V	2022.I-V
Бүгд	148	100	217
Үйлдэхдээ:			
-Бүлэглэсэн	37	4	71
-Согтуу байсан	60	57	56
Урьд ял шийтгэгдсэн	12	15	67
Эрүүлжигдсэн	237	176	177
Үүнээс: Баривчлуулсан хүн	68	54	70

I.5.4. СЭЖИГТЭН, ЯЛЛАГДАГЧИЙН ТОО, сумаар

Сум	2020.I-V	2021.I-V	2022.I-V
Асгат	1	2	5
Баяндэлгэр	12	2	1
Дарьганга	8	6	3
Мөнххаан	14	10	18
Наран	3	3	13
Онгон	2	-	6
Сүхбаатар	27	8	25
Түвшинширээ	5	2	8
Түмэнцогт	6	5	12
Уулбаян	11	3	5
Халзан	12	1	3
Эрдэнэцагаан	15	8	16
Баруун-Урт	32	50	56
Дүн	148	100	171

**II.1 МӨНГӨ, БАНК, ДААТГАЛ****II.1.1 ЗЭЭЛ, ХАДГАЛАМЖИЙН ҮЛДЭГДЭЛ, банкуудаар, сарын эцэст, сая.төг**

	Хэмжих нэгж	2020.V	2021.V	2022.V
Нийт зээлдэгч	тоо	24 498	22 321	29 783
Нийт зээлийн үлдэгдэл	тэрбум.төг	131.7	142.4	192.8
Анхаарал хандуулах зээлийн үлдэгдэл	тэрбум.төг	4.7	4.7	1.7
Чанаргүй зээлийн үлдэгдэл**	тэрбум.төг	3.1	2.6	1.5
Нийт хадгаламжийн данс эзэмшигчийн тоо /дансны тоогоор/	тоо	-	-	46 440
Нийт хадгаламжийн үлдэгдэл	тэрбум.төг	95.2	150.4	141.2
Хугацаагүй хадгаламжийн үлдэгдэл	тэрбум.төг	18.1	42.5	16.7
Хугацаатай хадгаламжийн үлдэгдэл	тэрбум.төг	59.8	107.9	124.6
Нийт банкны салбар, нэгж	тоо	35	35	35
Нийт банкны салбар, нэгжийн ажилтан	тоо	216	218	208
Нийт АТМ	тоо	25	27	27
Нийт төлбөрийн карт эзэмшигч	тоо	56 114	64 477	68 412

Тайлбар: Өмнөх онуудад хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээл нэгдсэн дүнгээр гардаг байсан нь өөрчлөлт орсон.

II.2 ТӨРИЙН САНХҮҮ**II.2.1 ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, сая.төг**

	2021.V	2022.V			2022.V / 2021.V %
		төл	гүйц	%	
1. Орон нутгийн төсвийн нийт орлого	30 007.7	30 034.1	27 599.6	91.9	92.0
1.1 Орон нутгийн төсөв	4 917.9	10 549.2	5 151.9	48.8	104.8
Аймгийн төсвийн орлого	3 575.2	5 156.3	1 260.7	24.4	35.3
Сумдын төсвийн орлого	1 342.7	5 392.9	3 891.2	72.2	2.9*
1.2 Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	3 842.3	3 491.0	3 491.0	100.0	90.9
Аймгийн авсан санхүүгийн дэмжлэг	-	2 303.5	1 886.9	81.9	-
1.3 Улсын төсвөөс олгох тусгай зориулалтын дэмжлэг	13 677.9	-	-	-	-
1.4 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас ол	3 528.7	4 941.2	4 494.9	91.0	127.4
1.5 Урьд оны үлдэгдэл / орон нутгийн орлого/	840.6	2 532.2	5 223.3	206.3	6.2*
1.6 Урьд оны үлдэгдэл / Төсөвт байгууллага/	2 064.7	4 803.2	6 747.9	140.5	3.3*
1.7 Төсөвт байгууллага / өөрийн орлого/	1 031.8	1 413.8	603.7	42.7	58.5
1.8 ЭМДсангаас	103.8	-	-	-	-



II.2.2 ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА, сая.төг

	2021.V	2022.V			2022.V 2021.V %
		төл	гүйц	%	
2. Орон нутгийн төсвийн нийт зарлага	29 247.0	30 034.1	24 867.2	82.8	85.0
2.1 Аймгийн шууд харъяаны байгууллагын зарлага	5 468.3	6 677.8	4 117.4	61.7	75.3
Аймгийн орон нутгийн хөгжлийн сан	-	102.4	-	-	-
Халамжийн сан	21.0	74.2	60.4	81.4	2.9*
2.1 Шууд харьцдаг байгууллагын зарлага	2 168.8	2 492.6	1 684.8	67.6	77.7
Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө	216.7	260.0	108.0	41.5	49.8
Замын сан	-	310.0	-	-	-
Засаг дарга	393.5	1 135.1	377.3	33.2	95.9
Сумдад олгосон санхүүгийн дэмжлэг	2 668.3	2 303.5	1 886.9	81.9	70.7
2.2 Сумдын тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зарлага	13 092.1	-	-	-	-
2.2 Аймгийн соёлын байгууллагуудын УБТ тогтмол зардал	-	332.8	304.6	91.5	-
2.3 Сумдын орон нутгийн байгууллагуудын зарлага	6 122.4	9 265.9	7 598.4	82.0	124.1
2.4 Аймгийн тусгай зохиулалтын шилжүүлгийн байгууллагын зарлага	585.7	-	-	-	-
2.4 Аймгийн байгууллагуудын зарлага	-	613.6	477.0	77.7	-
Сумдын байгууллагуудын УБТ тогтмол зарлага	-	1 985.8	1 333.9	67.2	-
Тусгай зохиулалтын шилжүүлгийн байгууллагын зарлага /орон нутгаас/	1 999.7	-	-	-	-
2.5 Аймаг, сумын орон нутгийн хөгжлийн сан	843.2	4 941.2	3 491.0	-	-
Урьд оны үлдэгдэл / Төсөвт байгууллага/	-	4 803.2	6747.9	140.5	-
Төсөвт байгууллага / өөрийн орлого/	1 031.8	1 413.8	797	56.4	77.2
ЭМДсангаас	103.8	-	-	-	-



II.2.3 АЙМГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, сумаар, сая.төг

	2021.V	2022.V		Татварын орлого		Татварын бус орлого		Санхүүгийн дэмжлэг	
		төл	гүйц	төл	гүйц	төл	гүйц	төл	гүйц
Асгат	799.1	395.0	329.6	105.2	72.2	1.5	1.9	288.3	255.4
Баяндэлгэр	1 449.9	519.0	332.7	306.1	158.7	17.8	17.2	195.1	156.8
Дарьганга	1 042.9	321.8	253.8	134.0	100.4	10.0	11.1	177.8	142.3
Мөнххаан	1 311.2	349.6	303.6	109.6	107.6	25.2	24.2	214.9	171.9
Наран	722.4	298.2	260.2	65.7	69.7	1.0	2.8	231.5	187.7
Онгон	1 458.6	363.1	320.2	247.6	232.6	12.9	5.4	102.7	82.1
Сүхбаатар	2 610.0	407.9	273.3	294.0	160.7	10.0	8.6	104.0	104.0
Түвшинширээ	1 134.8	394.6	279.4	102.3	115.1	65.4	5.5	226.8	158.8
Түмэнцогт	1 335.6	396.6	276.6	100.6	126.1	144.5	29.3	151.5	121.2
Уулбаян	977.5	349.4	267.3	95.2	81.1	26.8	4.3	227.3	181.9
Халзан	750.0	278.5	221.7	68.9	38.6	2.9	17.8	206.7	165.4
Эрдэнэцагаан	1 694.6	784.6	486.7	541.6	332.9	66.1	17.0	176.8	136.8
Баруун-Урт	6 224.3	2 838.1	2 150.4	2 577.5	1 993.2	260.6	157.2	-	-
Сумын дүн	21 510.9	7 696.4	5 755.5	4 748.3	3 358.5	642.2	290.9	2 303.4	1 864.3
Аймгийн төсөв	8 496.8	6 343.7	3 026.5	3 143.7	783.1	2 012.4	616.7	1 187.4	1 626.7
Аймгийн дүн	30 007.7	14 040.1	8 782.0	7 892.0	4 141.6	2 654.6	907.6	3 490.8	3 491.0

II.2.4 АЙМГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА, сумаар, сая.төг

Сум	2021.IV	2022.IV		Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		Нийгмийн даатгалын шимтгэл		Байр ашиглалт		Хангамжийн материал	
		төл	гүйц	төл	гүйц	төл	гүйц	төл	гүйц	төл	гүйц
Асгат	646.9	731.8	364.1	189.7	182.3	24.8	24.1	82.4	36.0	13.8	11.9
Баяндэлгэр	1 245.6	1 534.3	747.1	262.6	229.4	32.2	30.1	126.6	68.1	15.4	13.9
Дарьганга	977.5	966.4	454.6	204.2	187.2	25.5	23.1	162.8	116.4	15.0	12.5
Мөнххаан	1 228.9	1 118.1	718.7	250.0	221.3	31.3	30.0	139.0	97.6	19.8	19.2
Наран	566.4	698.7	432.6	163.0	137.2	20.1	17.2	100.4	40.7	9.8	8.9
Онгон	1 113.8	1 341.5	516.2	204.0	195.6	24.1	22.5	197.7	151.7	14.0	10.8
Сүхбаатар	1 327.1	3 412.0	1 237.1	205.7	182.2	25.6	24.1	223.2	140.2	13.2	7.0
Түвшинширээ	941.3	901.2	517.1	225.9	217.2	26.7	26.7	136.7	78.7	10.0	9.0
Түмэнцогт	1 000.4	1 477.4	736.8	204.3	179.5	25.6	22.9	223.6	166.2	15.2	10.4
Уулбаян	792.8	768.5	404.8	219.4	192.0	26.4	23.9	126.0	52.6	9.5	8.5
Халзан	698.5	787.1	400.2	177.5	164.1	21.8	19.3	144.5	129.4	7.7	5.8
Эрдэнэцагаан	1 443.4	2 049.9	961.4	273.3	229.4	35.5	26.0	193.1	125.2	25.0	19.9
Баруун-Урт	6 082.7	3 659.3	2 530.3	818.6	767.2	104.4	95.2	1 123.1	730.8	38.0	30.6
Сумын дүн	18 065.3	19 446.2	10 021.0	3 398.2	3 084.6	424.0	385.1	2 979.1	1 933.6	206.4	168.4
Аймгийн төсөв	3 736.8	10 057.9	5 252.0	1 011.7	914.4	124.1	105.4	753.3	631.0	100.7	71.0
Аймгийн дүн	21 802.1	29 504.1	15 273.0	4 409.9	3 999.0	548.1	490.5	3 732.4	2 564.6	307.1	239.4

Тайлбар: Санхүү төрийн сангийн хэлтсийн мэдээгээр

**II.3 ҮНЭ****II.3.1 ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС**

Барааны бүлгээр	$\frac{2022.V}{2021.V}$	$\frac{2022.V}{2021.XII}$	$\frac{2022.V}{2022.IV}$
ЕРӨНХИЙ ИНДЕКС	115.5	106.4	101.1
ХҮНСНИЙ БАРАА, СОГТУУРУУЛАХ БУС УНДАА	117.2	111.2	101.5
Хүнсний бараа	118.4	111.9	101.6
Талх, гурил, будаа	114.1	106.2	100.6
Мах, махан бүтээгдэхүүн	103.0	117.1	100.5
Сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөг	125.4	110.5	100.5
Төрөл бүрийн өөх, тос	146.4	111.4	105.4
Жимс, жимсгэнэ	128.5	105.2	102.3
Төмс, хүнсний ногоо	153.8	129.6	104.8
Саахар, жимсний чанамал, чихэр, шоколад	120.0	107.8	103.0
Хүнсний бусад бүтээгдэхүүн	127.0	111.8	105.8
Согтууруулах бус ундаа	104.6	103.5	100.2
СОГТУУРУУЛАХ УНДАА, ТАМХИ, МАНСУУРУУЛАХ БОДИС	103.9	100.4	100.3
Согтууруулах ундаа	106.0	100.1	101.2
Тамхи	103.1	100.5	100.0
ХУВЦАС, БӨС БАРАА, ГУТАЛ	112.9	101.9	100.9
Хувцас, бөс бараа	117.9	102.9	101.3
Хөвөн бөс, бараа	128.8	118.7	100.0
Бүх төрлийн хувцас	117.3	102.0	101.0
Жижиг эдлэл, хэрэгсэл	125.3	116.0	107.1
Гутал	102.7	99.7	100.1
ОРОН СУУЦ, УС, ЦАХИЛГААН, ХИЙН БОЛОН БУСАД ТҮЛШ	113.9	103.6	101.1
Орон сууцны бодит түрээс	108.7	100.0	100.0
Орон сууцны засвар, үйлчилгээ	125.9	102.9	103.0
Усан хангамж, бусад үйлчилгээ	110.9	110.9	100.0
Цахилгаан, хийн болон бусад түлш	106.7	102.7	100.0
ГЭР АХУЙН ТАВИЛГА, ГЭР АХУЙН БАРАА	122.1	109.1	102.8
Тавилга, хэрэгсэл, хивс, дэвсгэр	125.2	111.1	102.5
Оёмол, нэхмэл эдлэл	111.2	106.3	100.0
Цахилгаан бараа	118.0	102.7	100.6
Шилэн эдлэл, сав суулга	125.3	103.9	114.6
Багаж хэрэгсэл	132.1	121.3	100.0
Цэвэрлэгээний болон бусад жижиг бараа	121.1	107.8	106.1
ЭМ, ТАРИА, ЭМНЭЛЭГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	119.0	109.0	101.8
Эм, тариа, эмнэлэгийн хэрэгсэл	123.0	108.9	102.4
Амбулаторийн үйлчилгээ	100.0	100.0	100.0
Эмнэлэгт хэвтэж эмчлүүлэх үйлчилгээ	120.2	120.2	100.0
ТЭЭВЭР	122.4	105.1	100.0
Тээврийн хэрэгслийн худалдан авалт	100.3	100.3	100.0
Хувийн тээврийн хэрэгслийн засвар, үйлчилгээ	144.9	110.3	100.1
Тээврийн үйлчилгээ	137.8	100.0	100.0
ХОЛБООНЫ ХЭРЭГСЭЛ, ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	100.0	100.0	100.0
АМРАЛТ, ЧӨЛӨӨТ ЦАГ, СОЁЛЫН БАРАА ҮЙЛЧИЛГЭЭ	103.3	101.5	100.0
Дуу, дүрс, гэрэл зураг, бусад тоног төхөөрөмж	102.4	100.0	102.4
Чөлөөт цаг, соёлын үйлчилгээ	104.7	104.1	100.0
Ном, сонин бичгийн хэрэгсэл	103.0	100.9	100.0
БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ	103.5	102.1	100.0
ЗОЧИД БУУДАЛ, НИЙТИЙН ХООЛ, ДОТУУР БАЙРНЫ ҮЙЛЧИЛГЭЭ	110.4	102.7	104.2
Нийтийн хоолны үйлчилгээ	114.7	103.8	105.8
Зочид буудал, дотуур байрны үйлчилгээ	100.0	100.0	100.0
БУСАД БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ	114.3	110.0	100.8
Хувь хүнд хандсан үйлчилгээ	118.4	113.1	101.0
Хувь хүний эд зүйл, хэрэглэл	102.8	100.6	100.0
Санхүүгийн үйлчилгээ	100.0	100.0	100.0



II.3.2 ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ, хүнсний гол нэр төрлийн барааны үнэ

Нэр төрөл	2020.V	2021.V	2022.V	$\frac{2022.V}{2021.V}$ %
1-р зэргийн гурил, кг	1 333	1 513	1 567	103.6
Хонины мах /цул/, кг	9 500	11 600	12 000	103.4
Үхрийн мах /цул/, кг	11 000	12 700	13 500	106.3
Ямааны ястай мах, кг	8 125	10 400	10 000	96.2
Элсэн чихэр, кг	1 917	2 357	3 017	128.0
Цагаан будаа, кг	2 550	2 183	3 050	139.7
Шингэн сүү, л	2 350	2 700	2 500	92.6
Ноолуур, кг	58 750	116 000	50 000	43.1
Бензин, А-80, 1 литр	1 508	1 545	2 503	162.0
Бензин, А-92, 1 литр	1 578	1 587	2 555	161.0
Дизелийн түлш, литр	2 280	2 337	3 530	151.0
Боодолтой өвс	7 000	6 600	-	-

II.3.3 ХӨДӨӨ АЖ АХУЙН ЗАРИМ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН ДУНДАЖ ҮНЭ

Бүтээгдэхүүний төрөл	2020.V	2021.V	2022.IV	$\frac{2022.V}{2021.V}$ %
Адууны дэл	5 500	5 500	-	-
Адууны сүүл	6 500	8 000	-	-
Адууны шир	5 000	-	-	-
Үхрийн шир 1.8-2.3 метрийн хэмжээтэй	5 000	-	-	-
Үхрийн шир 2.3 метрээс дээш хэмжээтэй	5 000	-	-	-
Хонины ноостой нэхий	1 000	-	-	-
Ямааны ноолууртай арьс	-	-	-	-
Сонгино	2 700	2 100	3 200	152.4
Сармис	-	-	-	-
Өргөст хэмх	5 500	6 500	-	-
Улаан лооль	-	6 750	-	-
Тарвас	-	5 500	-	-
Өндөг	320	465	475	102.2

**II.4 ХӨДӨӨ АЖ АХУЙ****II.4.1 МАЛ ТӨЛЛӨЛТ, эх малын төрлөөр**

Малын төрөл	Төллөсөн хээлтэгч			Төллөлтийн хувь		
	2020.I-V	2021.I-V	2022.I-V	2020.I-V	2021.I-V	2022.I-V
Ингэ	1 143	902	1 161	36.3	30.1	38.1
Гүү	58 461	61 556	77 470	55.4	56.6	66.2
Үнээ	61 584	65 502	82 249	58.1	59.3	67.9
Эм хонь	762 936	764 207	865 267	86.0	81.4	84.5
Эм ямаа	464 034	460 764	498 625	84.1	78.9	82.3
Бүгд	1 348 158	1 352 931	1 524 772	82.1	77.6	81.5

II.4.2 МАЛ ТӨЛЛӨЛТ, сумаар

Сум	Төллөсөн хээлтэгч			Төллөлтийн хувь		
	2020.I-V	2021.I-V	2022.I-V	2020.I-V	2021.I-V	2022.I-V
Асгат	58 952	55 985	68 242	80.7	73.4	82.6
Баяндэлгэр	150 016	161 196	182 932	69.5	73.8	79.5
Дарьганга	76 983	72 092	82 900	76.5	74.8	78.2
Мөнххаан	170 851	161 064	173 367	81.0	77.7	80.5
Наран	51 032	48 912	53 740	80.3	83.0	85.5
Онгон	110 649	117 595	123 333	73.7	75.5	76.4
Сүхбаатар	121 585	114 107	158 050	81.0	71.1	85.4
Түвшинширээ	107 287	113 463	133 396	72.7	76.5	81.1
Түмэнцогт	49 857	45 195	47 093	74.9	70.2	74.8
Уулбаян	88 161	87 868	98 306	76.7	78.9	79.3
Халзан	52 847	57 856	61 026	77.3	83.7	80.7
Эрдэнэцагаан	149 801	149 210	159 774	8.1	85.1	87.1
Баруун-Урт	160 137	168 388	182 613	83.2	83.3	84.2
Бүгд	1 348 158	1 352 931	1 524 772	82.1	77.6	81.5



II.4.3 ТӨЛ БОЙЖИЛТ, төлийн төрлөөр

Малын төрөл	Бойжуулсан төл			Бойжилтын хувь		
	2020.I-V	2021.I-V	2022.I-V	2020.I-V	2021.I-V	2022.I-V
Ботго	1 136	888	1 152	99.4	98.5	99.2
Унага	57 783	61 027	77 055	98.8	99.1	99.5
Тугал	60 986	64 984	81 793	99.0	99.2	99.4
Хурга	756 444	760 756	861 572	99.0	99.3	99.4
Ишиг	458 582	456 435	494 371	98.5	98.6	98.8
Бүгд	1 334 931	1 344 090	1 515 943	98.8	99.1	99.2

II.4.4 ТӨЛ БОЙЖИЛТ, сумаар

Сум	Бойжуулсан төл			Бойжилтын хувь		
	2020.I-V	2021.I-V	2022.I-V	2020.I-V	2021.I-V	2022.I-V
Асгат	58 644	55 416	67 956	99.3	98.9	99.5
Баяндэлгэр	149 935	161 244	182 932	99.9	100.0	100.0
Дарьганга	75 074	71 132	82 529	96.8	97.9	98.9
Мөнххаан	166 348	155 063	165 995	96.9	95.8	95.5
Наран	50 028	48 786	53 784	97.6	99.1	99.4
Онгон	109 985	117 495	123 425	99.4	99.9	99.9
Сүхбаатар	121 204	114 729	158 757	99.7	99.9	99.9
Түвшинширээ	106 437	113 658	133 876	99.0	100.0	100.0
Түмэнцогт	47 273	43 198	46 116	94.6	95.0	96.9
Уулбаян	87 632	87 874	98 306	99.4	100.0	100.0
Халзан	53 296	58 192	61 216	100.0	100.0	100.0
Эрдэнэцагаан	149 518	148 538	158 995	99.8	99.5	99.4
Баруун-Урт	159 557	168 765	182 056	99.5	99.7	99.7
Бүгд	1 334 931	1 344 090	1 515 943	98.8	99.1	99.2



II.4.1 ЗҮЙ БУСЫН ХОРОГДОЛ ТОМ МАЛ, малын төрлөөр

Малын төрөл	Хорогдол бүгд			Оны эхний малд том малын хорогдлын эзлэх хувь		
	2020.I-V	2021.I-V	2022.I-V	2020.I-V	2021.I-V	2022.I-V
Тэмээ	16	23	21	0.2	0.3	0.3
Адуу	1166	1 448	1 187	0.4	0.4	0.3
Үхэр	2 331	3 520	1 160	0.9	1.3	0.4
Хонь	15 823	15 214	3 727	0.8	0.8	0.2
Ямаа	12 192	17 053	4 003	1.0	1.3	0.3
Бүгд	31 528	37 258	10 098	0.8	1.0	0.2

II.4.2 ЗҮЙ БУСЫН ХОРОГДОЛ ТОМ МАЛ, сумаар

Сум	Хорогдол бүгд			Оны эхний малд том малын хорогдлын эзлэх хувь		
	2020.I-V	2021.I-V	2022.I-V	2020.I-V	2021.I-V	2021.I-V
Асгат	746	5 349	182	0.4	2.9	0.1
Баяндэлгэр	2 438	8 863	240	0.5	1.8	0.0
Дарьганга	3 523	2 816	1 239	1.6	1.3	0.5
Мөнххаан	4 523	7 492	5 945	1.1	1.7	1.3
Наран	2 242	603	257	1.7	0.5	0.2
Онгон	130	1 634	-	0.0	0.5	-
Сүхбаатар	1 049	1 560	31	0.3	0.4	0.0
Түвшинширээ	4 763	655	111	1.5	0.2	0.0
Түмэнцогт	4 109	4 315	1 144	2.9	3.2	0.9
Уулбаян	4 472	349	-	1.8	0.1	-
Халзан	385	748	-	0.2	0.5	-
Эрдэнэцагаан	293	1 531	143	0.1	0.4	0.0
Баруун-Урт	2 855	1 343	806	0.7	0.3	0.2
Бүгд	31 528	37 258	10 098	0.8	1.0	0.2



II.4.7 ӨВЧНӨӨР ХОРОГДСОН МАЛ, малын төрлөөр

Малын төрөл	Өвчнөөр хорогдсон мал			Нийт хорогдсон малд эзлэх хувь		
	2020.I-V	2021.I-V	2022.I-V	2020.I-V	2021.I-V	2022.I-V
Тэмээ	-	-	-	-	-	-
Адуу	1	-	-	0.1	-	-
Үхэр	10	5	21	0.4	0.1	0.2
Хонь	60	-	45	0.4	-	0.4
Ямаа	65	-	53	0.5	-	0.5
Бүгд	136	5	119	0.4	0.0	1.2

II.4.8 ӨВЧНӨӨР ХОРОГДСОН МАЛ, сумаар

Сум	Өвчнөөр хорогдсон мал			Хорогдсон нийт малд эзлэх хувь		
	2020.I-V	2021.I-V	2022.I-V	2020.I-V	2021.I-V	2021.I-V
Асгат	-	-	6	-	-	0.1
Баяндэлгэр	-	5	-	-	0.1	-
Дарьганга	-	-	-	-	-	-
Мөнххаан	-	-	6	-	-	0.1
Наран	-	-	-	-	-	-
Онгон	-	-	-	-	-	-
Сүхбаатар	-	-	-	-	-	-
Түвшинширээ	-	-	-	-	-	-
Түмэнцогт	125	-	-	3.0	-	-
Уулбаян	-	-	-	-	-	-
Халзан	-	-	-	-	-	-
Эрдэнэцагаан	11	-	-	3.8	-	-
Баруун-Урт	-	-	107	-	-	1.1
Бүгд	136	5	119	0.4	0.0	1.2

**II.5 АЖ ҮЙЛДВЭР****II.5.1 АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН, 2010 оны зэрэгцүүлэх үнээр, сая.төг**

Аж үйлдвэрийн салбар	2021.I-V	2022.I-V	Дүнд эзлэх хувь	
			2021.I-V	2022.I-V
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	16 723.8	17 818.8	82.6	85.5
Нүүрс	2 746.9	555.7	13.6	2.7
Цайрын баяжмал	8 378.7	11 429.4	41.4	54.8
Төмрийн хүдрийн баяжмал	-	-	-	-
Хайлуур жоншны баяжмал	5 586.7	4 241.2	27.6	20.3
Хайлуур жонш	11.6	1591.5	0.1	7.6
Хайрга	-	-	-	-
Боловсруулах аж үйлдвэр	1 511.1	832.2	7.5	4.0
Хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэлт	1 427.0	750.4	7.1	3.6
Дээрхи ангид ороогүй бусад үйлдвэрлэл	84.1	81.7	0.4	0.4
Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, усан хангамж	2 000.9	2 194.3	9.9	10.5
Цахилгаан, дулаан, уур үйлдвэрлэл	1 922.7	2 109.4	9.5	10.1
Ус хуримтлуулах, ариутгах, усан хангамжийн үйл ажиллагаа	78.3	84.9	0.4	0.4
Дүн	20 235.9	20 844.3	100.0	100.0

II.5.2 АЖ ҮЙЛДВЭРИЙН БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН, оны үнээр, сая.төг

Аж үйлдвэрийн салбар	2021.I-V	2022.I-V	Дүнд эзлэх хувь	
			2021.I-V	2022.I-V
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	97 124.6	95 378.2	89.3	90.4
Нүүрс	5 495.5	728.9	5.1	0.7
Цайрын баяжмал	73 029.1	89 058.2	67.2	84.4
Төмрийн хүдрийн баяжмал	5 539.9	-	5.1	-
Хайлуур жоншны баяжмал	12 523.9	5 308.1	11.5	5.0
Хайлуур жонш	536.2	282.9	0.5	0.3
Хайрга	-	-	-	-
Боловсруулах аж үйлдвэр	4 650.9	2 106.4	4.3	2.0
Хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэлт	4 463.3	1 894.0	4.1	1.8
Дээрхи ангид ороогүй бусад үйлдвэрлэл	187.6	212.4	0.2	0.2
Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, усан хангамж	6 930.5	8 041.4	6.4	7.6
Цахилгаан, дулаан, уур үйлдвэрлэл	6 616.0	7 665.2	6.1	7.3
Ус хуримтлуулах, ариутгах, усан хангамжийн үйл ажиллагаа	314.5	376.2	0.3	0.4
Дүн	108 706.0	105 526.0	100.0	100.0



II.5.3 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, оны үнээр, сая.төг

Гол нэр төрлийн бүтээгдэхүүн	2021.V	2021.I-V	2022.V	2022.I-V	$\frac{2022.I-V}{2021.I-V}$ %
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	13 085.1	34 553.7	8 194.4	36 663.2	106.1
Хүрэн нүүрс	234.0	3 008.9	-	728.9	24.2
Цайрын баяжмал	6 495.7	19 558.9	6 804.4	27 795.9	142.1
Төмрийн хүдрийн баяжмал	-	-	-	-	-
Хайлуур жоншны баяжмал	6 355.4	11 449.8	1 066.9	6 375.1	55.7
Хайлуур жонш	-	536.1	323.1	1 763.3	3.3*
Хайрга, шороо	-	-	-	-	-
Цахилгаан дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж	540.7	6 215.2	781.3	7 737.7	124.5
Дулааны эрчим хүч	93.0	3 410.6	236.7	4 401.6	129.1
Түгээсэн цэвэр ус	44.8	135.9	80.1	376.2	2.8*
Цахилгаан	402.9	2 668.7	464.6	2 959.9	110.9
Хүнсний бүтээгдэхүүн, ундаа, ус үйлдвэрлэл	1 807.9	4 463.5	662.3	1 818.3	40.7
Бууз, банш	12.8	46.1	15.1	51.1	110.9
Бялуу	7.0	33.6	15.7	68.4	203.5
Зайрмаг	3.6	9.6	-	-	-
Нарийн боов	37.0	133.8	17.8	127.6	95.3
Хэвийн боов	1.8	167.7	2.5	175.0	104.4
Талх	77.0	225.0	77.5	323.5	143.8
Хэрчсэн гурил	13.7	21.6	9.4	56.9	2.6*
Хийжүүлсэн цэвэр ус, рашаан	15.3	74.7	17.4	70.8	94.8
Борц	-	-	37.8	75.6	-
Адууны мах	820.1	958.1	66.3	115.9	12.1
Үхрийн мах	103.6	406.3	3.3	48.2	11.9
Хонины мах	597.6	1 604.8	328.3	599.5	37.4
Ямааны мах	118.4	782.2	71.3	105.9	13.5
Хувцас үйлдвэрлэл	7.1	78.8	19.5	131.5	166.9
Ажлын болон тамирын хувцас	0.4	3.8	-	0.9	23.6
Дээлнээс бусад монгол хувцас	1.3	5.7	1.5	13.8	242.5
Гутал	0.8	5.6	0.7	5.9	105.2
Монгол дээл,тэрлэг	4.3	59.5	11.7	80.6	135.4
Оёмол хүрэм	0.2	2.9	0.5	5.3	181.2
Өмд	0.1	0.2	0.1	0.3	150.0
Бусад хувцас	-	0.5	0.1	0.3	67.9
Гэрийн бүрээс, туурга болон бусад хэрэгсэл	-	0.6	3.9	19.5	32.5*
Морины нэмнээ болон бусад хэрэгсэл	-	-	1.1	5.0	-
Модон эдлэл	6.0	38.8	4.5	50.5	130.1
Гал тогооны өрөөний модон тавилга	3.0	15.3	-	2.2	14.4
Гэрийн бусад модон тавилга	3.0	17.6	0.4	40.4	229.7
Модон сандал	-	0.5	1.0	2.4	4.7*
Гэрийн мод болон бусад хэрэгсэл	-	-	0.5	1.4	-
Төрөл бүрийн модон эдлэл	-	5.4	2.6	4.1	76.3
Барилгын бүтээгдэхүүн үйлдвэрлэл	64.0	64.0	18.4	27.4	42.8
Бетон зуурмаг	-	-	-	-	-
Блок	56.7	56.7	18.4	27.4	48.3
Бакум цонх	7.3	7.3	-	-	-
ДҮН	15 510.8	45 414.0	9 680.4	46 428.6	102.2



II.5.4 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ, гол нэр төрлөөр

Гол нэр төрлийн бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	2021.V	2021.I-V	2022.V	2022.I-V	$\frac{2022.I-V}{2021.I-V}$ %
Уул уурхай, олборлох аж үйлдвэр						
Хүрэн нүүрс	мян.тн	49.8	157.7	-	31.9	20.2
Цайрын баяжмал	мян.тн	7.2	23.1	7.3	31.5	136.4
Төмрийн хүдрийн баяжмал	мян.тн	-	-	-	-	-
Хайлуур жоншны баяжмал	мян.тн	7.6	15.2	1.0	5.2	34.3
Хайлуур жонш	мян.тн	-	0.8	0.8	4.5	5.8*
Хайрга, шороо	мян.м3	-	-	-	-	-
Цахилгаан дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж						
Дулааны эрчим хүч	мян.гкал	2.3	56.1	2.4	59.8	106.7
Түгээсэн цэвэр ус	мян.м3	47.3	198.8	42.6	215.7	108.5
Цахилгаан	сая.квт	2.4	18.6	3.3	20.7	111.3
Хүнсний бүтээгдэхүүн, ундаа, ус үйлдвэрлэл						
Бууз, банш	тн	1.8	6.0	2.0	6.5	108.7
Бялуу	тн	0.3	1.5	0.8	3.0	196.9
Зайрмаг	мян.ш	0.7	0.8	-	-	-
Нарийн боов	тн	10.9	34.5	6.7	38.8	112.6
Хэвийн боов	тн	3.8	33.2	0.4	27.3	82.1
Талх	тн	45.7	123.5	43.0	186.5	151.0
Хэрчсэн гурил	тн	5.9	6.3	5.1	32.2	5.1*
Хийжүүлсэн цэвэр ус, рашаан	мян.л	97.6	417.4	86.3	418.9	100.4
Борц	тн	-	-	0.6	1.2	-
Адууны мах	тн	82.9	105.9	10.5	19.5	18.4
Үхрийн мах	тн	10.5	50.9	-	5.5	10.8
Хонины мах	тн	66.4	212.4	36.7	70.9	33.4
Ямааны мах	тн	16.2	130.7	9.9	19.1	14.6
Хувцас үйлдвэрлэл						
Ажлын болон тамирын хувцас	ш	7	87	-	14	16.1
Дээлнээс бусад монгол хувцас	ш	35	112	37	278	248.2
Гутал	хос	6	40	5	46	115.0
Монгол дээл,тэрлэг	ш	81	701	138	1 033	147.4
Оёмол хүрэм	ш	3	52	2	63	121.2
Өмд	ш	4	9	-	19	211.1
Бусад хувцас	ш	-	6	5	42	7.0*
Гэрийн бүрээс, туурга болон бусад	ш	-	-	25	165	-
Морины нэмнээ болон бусад	ш	-	-	40	111	-
Модон эдлэл						
Гал тогооны өрөөний модон тавилга	ш	1	13	-	4	30.8
Гэрийн бусад модон тавилга	ш	8	34	4	32	94.1
Модон сандал	ш	-	29	5	23	79.3
Гэрийн мод болон бусад хэрэгсэл	ш	-	-	2	9	-
Төрөл бүрийн модон эдлэл	ш	-	25	2	17	68.0
Барилгын бүтээгдэхүүн үйлдвэрлэл						
Бетон зуурмаг	м3	-	-	-	-	-
Блок	мян.ш	32.5	32.5	9.2	13.7	42.2
Бакум цонх	м3	-	-	-	-	-



Хаяг: Сүхбаатар аймаг, Баруун-Урт сум
Аймгийн нутгийн удирдлагын ордон, 119 тоот
Вэб сайт: <http://sukhbaatar.nso.mn>
Фесбүүк хуудас: <https://www.facebook.com/statistic>
Холбоо барих утас: 70518819, 70518203
И-мэйл: sukhbaatar@nso.mn

Үндэсний Статистикийн хорооны мэдээллийн сайт: <http://www.nso.mn>
Статистик мэдээллийн нэгдсэн сангийн сайт: <http://www.1212.mn>
Аймгийн мэдээллийн сайт: <http://sukhbaatar.mn>

СТАТИСТИК -
ХӨГЖИЛД ХӨТЛӨГЧ ХҮЧ